

НИЙСЛЭЛИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР
/Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн тайлан/

2017 оны 12 дугаар сарын 25

Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1086 тоот захирамжаар батлагдсан Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмын дагуу иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг хүлээн авч, бүртгэж, хянан шийдвэрлэж байна.

Байгууллагын хэмжээнд 2017 оны хэмжээнд 63 өргөдөл гомдол ирснийг журмын дагуу хугацаанд нь шийдвэрлэлээ. Ирсэн өргөдөл гомдлыг ангилж үзвэл ЭМАА хэлтэст 26, газар тариалангийн хэлтэст 37, үүнээс гомдол 5, санал 5, хүсэлт 53, өргөдөл гомдлыг хүлээн авсан эх үүсвэр 1800-1200 6, 11-11 төв 13, НҮТөв 17, нутгийн захиргааны байгууллага 27 тус тус ирүүлсэн байна.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмыг мөрдөж, асуудлыг бүрэн шийдвэрлэн, шийдвэрлэлтийн мэдээллийг газрын удирдлагын зөвлөл болон байгууллагын хурлаар тухай бүрд нь мэдээллэж, тайланг улирал бүр гаргаж НЗДТГ-т хүргүүлж ажиллалаа.

Ирсэн өргөдөл гомдолд анхаарал татсан, хандалт өндөртэй, дахин дахин хандаж байгаа өргөдөл гомдол байхгүй бөгөөд байгууллагын хэмжээнд өргөдөл гомдлын шийдвэрлэлт дундаж хугацаа 7 цаг 23 минут байна.

ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН 2017 ОНД ИРГЭДТЭЙ ХИЙСЭН УУЛЗАЛТЫН ТАЙЛАН

2017 оны 12 дугаар сарын 25

Нийслэлийн Засаг даргын А/69 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалт /Шилэн уулзалт/-д ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай журам”-ын дагуу арга хэмжээг авч ажиллаж байна.

2017 онд манай байгууллага нийт 524 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй уулзаж, иргэдийн тавьсан өргөдөл гомдол, санал хүсэлтийг бүх талаас нь судлан үзэж, түүний дагуу хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох арга хэмжээг авч тэдгээр хүмүүст мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, үйл ажиллагааг нь дэмжиж хамтран ажиллалаа.

Захиргааны хэлтэс 38, Хүнсний үйлдвэрлэлийн хэлтэс 22, Эрчимжсэн мал аж ахуйн хэлтэс 380 гаруй, Газар тариалангийн хэлтэс 84 иргэн, ААН-ийн төлөөлөлтэй уулзснаас салбарын хэмжээнд давтамж ихтэй асуудал хоргилсон бүсээс мал гаргах, мал мах худалдах, тусгай зөвшөөрөл сунгуулах, хүлэмж, жимс жимсгэний тариалалтын сургалтанд хамрагдах хүсэлт, ажилд орох хүсэлт, салбарын чиглэлийн бусад асуудлаар хамтран ажиллах санал ирүүлсэн байна.

Smart-аар 3 иргэн уулзах хүсэлт ирүүлснийг хүлээн авч хариуг хугацаанд нь хүргүүлсэн.

№	Хэлтэс	Уулзалтын тоо
1	Газрын дарга /Захиргааны хэлтэс/	38
2	Хүнсний үйлдвэрлэлийн хэлтэс	22
3	Эрчимжсэн мал аж ахуйн хэлтэс	380
4	Газар тариалангийн хэлтэс	84
Нийт		524

Иргэн, аж ахуй нэгжийн төлөөлөлтэй дараах асуудлаар уулзсан.

1.Газрын дарга /4 хэлтэс/

№	Уулзалтын төрөл	Уулзалтын тоо
1	Хамтарч ажиллах саналын талаар	15
2	Ажилд орох хүсэлт	11
3	Цаг үеийн асуудлаар	59
4	Гадаад харилцаа	5
5	Газар тариалангийн чиглэлээр	84
6	Хориглосон бүсээс мал гаргах, мал худалдах асуудлаар	350
Нийт		524